

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН 2022 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДААС ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ
БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ

2022.12.07

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт			
		Зарцуулсан хөрөнгө	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт хүрээгүй бол тайлбар
Нэг. Хууль тогтоомжийн сургалт, сурталчилгаа, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн бүртгэлийн чиглэлээр					
1.1.	Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиудаас хуулиар тусгайлан эрх олгогдсон заалтын дагуу захиргааны хэм хэмжээний акт боловсруулахад иргэд, иргэний нийгмийн байгууллагын саналыг сонсох, тусгах, зөвлөлдөх, хяналт тавих нөхцөлийг бүрдүүлж, оролцоог нэмэгдүүлэх	-	Батлагдсан захиргааны хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг Улсын нэгдсэн санд бүртгүүлсэн тоо	2	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас “Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай”, “Газрын төлбөрийн бүсийн хил зааг, итгэлцүүр төлбөрийн хэмжээг тогтоох тухай”, Гурвансайхан, Сайхан-Овоо, Өндөршил сумдын “Малын тоо толгойд 2022 онд ногдуулах албан татварын хэмжээ тогтоох тухай журам”, Дэлгэрцогт сумын “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох тухай журам”-уудыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн. Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 дугаар зүйлийг баримтлан аймгийн “Орон нутгийн санг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах түүнд хяналт тавих журам”-ыг боловсруулахаар www.dundgovi.gov.mn цахим хаягаар иргэдээс санал, хүсэлтийг хүлээн авч төсөлд тусган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит аравдугаар хуралдаанаар “Орон нутгийн санг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах түүнд хяналт тавих журам”-ын төслийг хэлэлцүүлэн баталж улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлсэн боловч тодорхой нөхцөл байдлаас шалтгаалан санд бүртгэгдээгүй хүлээгдэж байна. Хэрэгжилтийн хувь - 100
1.2.	Шинээр батлагдан гарсан хууль тогтоомжийг сурталчлан	2.6 сая.төгрөг	Сургалт, сурталчилгаа	10	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн

	таниулах ажлыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах, шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх	Орон нутгийн төсөв	зохион байгуулсан тоо		боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”, аймгийн Засаг даргын шийдвэрээр 2022 оныг “Хүний хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан шинээр батлагдан хэрэгжиж буй Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Захиргааны актад тавигдах шаардлага, Хөдөлмөрийн, Авлигын тухай хууль зэрэг хууль тогтоомжуудаар иргэд, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагчдын эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилт тавин тус хугацаанд цахимаар болон танхимын хэлбэрээр аймаг, сумдын эрх зүйн хөтчүүд хамтран эрх зүйн сургалтыг 131 удаа 7545 хүнд, сурталчилгааг 177 удаа зохион байгууллаа. Хэрэгжилтийн хувь - 100
Хоёр. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр					
2.1.	Иргэдэд хүргэх эрх зүйн сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх чиглэлээр сумдын ЗДТГ-ын дарга, “Эрх зүйн хөтөч” нарыг чадавхжуулах сургалт, семинар зохион байгуулж, удирдлага, арга зүй, мэдээ мэдээллээр хангаж, хамтран ажиллах.	2.5 сая.төг Орон нутгийн төсөв	Сургалт, семинарт хамрагдсан эрх зүй хөтчийн хувь	90	Сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарт шинээр батлагдан хэрэгжиж буй МУЗЗНДНТУТХ, Захиргааны ерөнхий хууль болон Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар сургалтуудыг зохион байгуулав. Сумдын “Эрх зүйн хөтөч” нарыг давтан сургах сургалтыг шинэчлэн батлагдсан хууль тогтоомжууд болон иргэд, олон нийтэд эрх зүйн боловсрол олгох, зөвлөгөө өгөх арга зүй, иргэдийн оролцоог хангах, нэмэгдүүлэх зэрэг 12 сэдвээр 2 өдөр зохион байгууллаа. Тайлангийн хугацаанд нийт 3 удаагийн сургалт, семинарыг зохион байгуулан, эрх зүйн хөтчүүдээр дамжуулан иргэдэд эрх зүйн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулан, аймгийн хэмжээнд бэлтгэгдсэн эрх зүйн хөтчүүдийг сургалтад бүрэн хамруулж эрх зүйн боловсрол олголоо. Хэрэгжилтийн хувь - 100

2.2.	Аймгийн ГХУСАЗСЗ-тэй хамтран олон нийтэд чиглэсэн нэгдсэн хууль зүйн тусламж, үйлчилгээ сургалт, сурталчилгааг 3-аас доошгүй сумдад зохион байгуулах.	2.1 сая.төг Орон нутгийн төсөв	Тухайн жилд хууль зүйн сургалт, сурталчилгаа зохион байгуулсан сумдын тоо	3	“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сум бүрт” арга хэмжээг Дэлгэрцогт, Өлзийт, Дэрэн, Говь-Угтаал, Цагаандэлгэр, Өндөршил, Баянжаргалан, Луус, Хулд зэрэг сумдын иргэд, албан хаагчдад, “Хууль тогтоомж сурталчлах” өдөрлөгийг Эрдэнэдалай сумын төрийн албан хаагчдад, Өлзийт сумын Тагт, Буянт багийн малчдад “Малчдын нэг өдөр” өдөрлөгийг аймгийн ГХУСАЗСЗ болон хууль хяналтын байгууллагуудтай хамтран 788 хүнд “Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдал, ойлголт”, “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх” “Авлига, ашиг сонирхлын зөрчил” зэрэг сэдвүүдээр иргэд олон нийтэд эрх зүйн сургалт, сурталчилгаа, хууль зүйн тусламж, үйлчилгээ үзүүлж, нэгдсэн арга хэмжээг зохион байгуулав. Хэрэгжилтийн хувь - 100
2.3.	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг иргэд, олон нийтийн оролцоотой хамтран хэрэгжүүлэх.	2.0 сая.төг Орон нутгийн төсөв	Авлигын эсрэг үйл ажиллагааны тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	92	Тус оны төлөвлөгөөг 14 зорилтын хүрээнд 60 арга хэмжээг төлөвлөн боловсруулж, хэрэгжилт 92.5 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжлээ. Хэрэгжилтийн хувь - 100
Гурав. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр					
3.1	Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг судалж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг бодитой төлөвлөж, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн хэрэгжилтийг ханган ажиллах.	Тухай бүр	Тухайн жилд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо	240	Тус оны 11 дүгээр сарын байдлаар тус аймагт үйлдэгдэж бүртгэгдсэн 220 гэмт хэрэгт 176 хүн холбогдсон ба эдгээрийн 10.8 хувь нь эмэгтэй хүн байна. Мөн гэмт хэрэгт холбогдогчдын 70.5 хувийг эрхэлсэн тодорхой ажилгүй болон малчин иргэд байна. Хүнийг санаатай алах гэмт хэрэг 4 нэгжээр буюу 2.3 дахин, хүчиндэх гэмт хэрэг 3 буюу 42.8 хувь, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 4 буюу 4.82 хувь, хулгайлах гэмт хэрэг 4 буюу 9.3 хувь, согтуугаар үйлдэгдсэн гэмт

					хэрэг 7 буюу 9.21 хувь, гэр бүлийн хүчирхийллийн умаас үйлдэгдсэн гэмт хэрэг 6 буюу 46.1 хувь, залилах гэмт хэрэг 2 буюу 6.25 хувь тус тус урд оны мөн үеэс өссөн. Статистик үзүүлэлтээс харахад эрэгтэйчүүдийн гэмт хэрэгт илүү өртдөг шалтгаан нь эрхэлсэн тодорхой ажилгүй, боловсролын түвшин бага, архи согтууруулах ундааны хэрэглээ өндөр, хууль эрх зүйн мэдлэг хангалтгүй зэргээс шалтгаалж байна. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 зүйлд заасны дагуу 2021 онд төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгээс 147.585.600 төгрөгийг 2022 оны аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардалд 100 хувь зарцуулж санхүүжүүлсэн. Хэрэгжилтийн хувь - 100
3.2.	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах байр байгуулж, сэтгэл зүйн тусламж, зөвлөгөө, мэдээллээр үйлчлэх үйл ажиллагааг нь тогтмолжуулах.	-	Түр хамгаалах байртай болсон эсэх /тийм-1 Үгүй-0/	1	Цагдаагийн газрын ашиглаж байсан хуучин барилгыг засварлаж, “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах”, “Иргэдийг гэр бүлийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээллээр үйлчлэх төв”-ийг байгуулахаар Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраар зураг төсвийг гаргуулж, 2023 оны орон нутгийн төсөвт 250.0 сая төгрөгийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлууллаа. Аймгийн Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын сэтгэл зүйчид холбон зуучилж хүчирхийлэлд өртсөн 45 иргэнд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үйлчилгээ, зөвлөгөө мэдээллээр ханган ажилласан. Хэрэгжилтийн хувь - 0
3.3.	Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр хууль сахиулах болон иргэний нийгмийн	-	АА бүлэг байгуулагдсан сумдын тоо	8	“Архигүй амьдралыг цогцлооё-Архигүй төрийн алба” аяны хүрээнд хууль сахиулах болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран “Архи, согтууруулах ундааны хэрэглээ, гэр бүлд үзүүлэх

	байгууллагуудтай хамтран ажиллах.				хор нөлөө” зэрэг сэдвүүдээр соён гэгээрүүлэх сургалт сурталчилгааг зохион байгуулан, архинд донтох өвчтэй нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон 4 иргэнийг шүүхийн шийдвэр гаргуулан, архины албадан эмчилгээнд хамруулсан. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Хууль эрх зүйн хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран “Гэмт хэргээс урьдчилан ажлыг сум бүрд” нээлттэй өдөрлөгийг зохион байгуулан 9 сумын 1450 иргэнд “Архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээ” сэдвээр сургалт, мэдээлэл хийсэн. Иргэдийн сайн дурын үндсэн дээр байгуулагдсан архинд донтох өвчнийг болон гэр бүлийн бусад гишүүдийг эдгэрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжин ажиллахаар аймгийн Засаг даргын 2022 оны А/95 дугаар захирамжаар “Мэргэжилтний баг” байгуулагдан үйл ажиллагаагаа эхлүүлж, тэдний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулж, үйл ажиллагааг идэвхжүүлэхээр Сайнцагаан сумын “Говийн хийморь” АА бүлгийн 9 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулж, “Сумын мэргэжилтний багийн ахлагч нар”-ыг чадавхжуулж, иргэдийн сайн дурын үндсэн дээр байгуулагдах архинд донтох өвчнийг эдгэрүүлэх үйл ажиллагааг дэмжин ажиллах ерөнхий чиг үүргээр хангаж, тусгайлсан сургалтыг зохион байгуулсан. Сайнцагаан, Эрдэнэдалай, Баянжаргалан, Цагаандэлгэр, Өлзийт зэрэг 5 суманд АА-гийн 8 бүлэг идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Хэрэгжилтийн хувь - 100
3.4	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх	-	Мал хулгайлах гэмт хэргийн тоо	26	Энэ оны 11 дүгээр сарын байдлаар аймгийн хэмжээнд мал хулгайлах гэмт хэрэг 11 бүртгэгдсэн

	ажиллагаанд иргэдийн сонор сэрэмж, хариуцлагыг нэмэгдүүлж, иргэний нийгмийн байгууллагын идэвх оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах				нь урьд оны мөн үетэй харьцуулахад 3 нэгжээр буюу 21.4 хувиар буурсан ба хэргийн илрүүлэлт 36.4 хувьтай байна. Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн 5 сумдын малчдыг хамруулан малчдын зөвлөгөөнийг зохион байгуулж, Мал эмнэлгийн алба хаагчдын нэгдсэн зөвлөгөөнд 1 удаагийн сургалт, 8 суманд зохион байгуулагдсан “Малчдын өдөр” өдөрлөгт 8 удаагийн яриа таниулга хийж нийт 3800 малчин иргэд, төрийн алба хаагчдыг хамруулсан. “Мал, мах-2022” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Дундговь аймагтай хил залгаа оршдог аймгуудын цагдаагийн газрын алба хаагчидтай мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хамтран ажиллах талаар цахим уулзалт зохион байгууллаа. Улсын хэмжээнд “Мал, мах-2022” нэгдсэн арга хэмжээ 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс 12 дугаар сарын 04-ний хугацаанд зохион байгуулагдаж байгаа ба уг арга хэмжээний хүрээнд цагдаагийн газрын алба гарал үүслийн зөвшөөрөлгүй мал, мах тээвэрлэсэн 19 зөрчил, энэ онд үйлдэгдсэн малын хулгайн 3 гэмт хэргийг илрүүлж, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан 3 тээврийн хэрэгслийг хураасан байна. Хэрэгжилтийн хувь - 100
3.5	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр үр нөлөөтэй нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулж, шаардлагатай хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах.	-	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлийн бууралтын тоо	28	Улсын хэмжээнд зохион байгуулсан “Гэрлээрээ анхааруулъя”, “Уусан бол бүү жолоод” нөлөөллийн, “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулан зам тээврийн ослын хор уршиг, түүнээс үүдэн гарах хор хохирлын талаар таниулах, иргэдэд замын хөдөлгөөнд аюулгүй, зөв оролцох мэдлэг мэдээлэл олгож, зөв дадалд хэвшүүлэх зорилгоор “Орон нутгийн замын цагдаа”,

					“Дундговь Цагдаагийн газар” facebook хуудсанд 9 удаа байршуулж, орон нутгийн замд зорчиж байгаа иргэд, жолооч нарт анхааруулга, сэрэмжлүүлэг тогтмол өгч ажиллалаа. Зам тээврийн гэмт хэрэг, ослын нөхцөл байдал, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр “Согтуугаар тээврийн хэрэгсэл бүү жолоод”, “Та бага насны хүүхдийг зориулалтын суудалд суулгаж аюулгүй зорчих”, “Хамгаалах бүсээ бүслэх гурван секунд таны ирээдүйн амьдралын баталгаа”, “Жолооны ард утсаар бүү оролд бүү ярь”, “Таны хурд хэтрүүлсэн хором мөч бүхэн хэн нэгний амьдралыг орвонгоор нь өөрчлөхөд бэлэн байдаг” гэх зэрэг 5 төрлийн 150 ширхэг санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмж замын хөдөлгөөнд оролцож буй жолооч нарт тарааж ажилласан. Энэ төрлийн гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 удаагийн подкаст, 2 төрлийн видео зохиомж, 13 төрлийн зурагт хуудас хийж байгууллагын цахим хуудас болон олон нийтийн сүлжээнд байршуулан нийт 1,538,000 хэрэглэгчийн хандалт хийгдсэн байна. Хүүхдийг зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд оролцох зөв дадалд сургах, аюулгүй байдлаа хэрхэн хангах талаар хууль, эрх зүйн мэдлэг олгох, тэдний эцэг, эх, асран хамгаалагч нарын үүрэг хариуцлагыг сайжруулах, сургуулийн багш, нийгмийн ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Ногоон гэрэл Цагаан шугам 2022” тэмцээнийг аймгийн Цагдаагийн газар, ГХУСАЗСЗ-тэй хамтран амжилттай зохион байгуулсан. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2022 оны 11 сарын
--	--	--	--	--	--

					байдлаар 19 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1 нэгжээр буюу 5,6 хувиар өссөн. Хэрэгжилтийн хувь - 100
3.6	Албан байгууллага, аж ахуйн нэгжийн санаачилга, оролцоотой аймаг, сумдын гэр хорооллын гудамж, нийтийн эзэмшлийн талбайн камерын тоог нэмэгдүүлэх, хүчин чадлыг сайжруулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх камержуулалтын системийн зураг төсөв боловсруулах	ОНТ	Нэмэгдүүлсэн камерын тоо	15	Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төлөвлөгөөнд “Камер-2022” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахаар тусгагдсаны дагуу сумдад 45 камерыг шинээр суурилуулан ашиглаж байна. Аймгийн Онцгой комиссын санхүүжилтээр аймгийн төвийн хуучин теле камеруудыг засварлаж, төв зам дагуух 10 цэгт 21 ширхэг камерыг суурилуулан, хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр Баянжаргалан суманд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэхээр 20.0 сая төгрөгийг шийдвэрлэн тендер зарлаж, тус сумын төвийг хяналтад авах 4 цэгт, 4 ширхэг PTZ теле камер байршуулан ашиглаж байна. Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд санал хүргүүлж, 2023 онд улсын төсвийн хөрөнгөөр Мандалговь хотыг бүрэн камержуулах зураг, төслийн ажилд шаардлагатай 30.0 сая төгрөгийг 2022 оны төсөвт тусгуулан тендерт шалгарсан “Сителком” компани зураг төслийн ажлыг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Хэрэгжилтийн хувь - 100
Дөрөв. Цагдаагийн байгууллагын чиглэлээр					
4.1	Цагдаагийн газарт шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг туслалцаа үзүүлэх.	7,0 сая төг Орон нутгийн төсөв	Үзүүлсэн дэмжлэг туслалаа	45,0 сая төг	Цагдаагийн газарт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилгоор энгэрийн камер 7, хэт богино долгионы радио холбоо 6, мөн богино долгионы радио холбооны нөөц тэжээл 20 ширхэг зэрэг

					12.700.000 төгрөгийн тоног төхөөрөмж, тусгай хэрэгсэл шийдвэрлүүлсэн. Цагдаагийн ерөнхий газрын Санхүү аж ахуйн албанд хүсэлт хүргүүлж, 7,0 сая төгрөгийн өртөг бүхий дахин дамжуулах станц шийдвэрлүүлсэн. Сайнцагаан сумын 9 дүгээр багийн нутаг дэвсгэрт 1 га газрыг шийдвэрлэн төмс, хүнсний ногоо, жимсний мод тариалсан. Цагдаагийн газрын насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах өрөөний засвар, тохижилтын ажилд 5.0 сая төгрөгний дэмжлэг үзүүлсэн. Эрүүлжүүлэх баривчлах байрны агааржуулах төхөөрөмжний 2.3 сая төгрөгийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шийдвэрлүүлсэн. Мөн цэрэгжсэн байгууллагуудын хүсэлтийн дагуу Сүлд дурсгалын талбайн газрыг шийдвэрлэж өгсөн. Хэрэгжилтийн хувь - 100
4.2	Сумдын Цагдаагийн хэсгийн кабоны урсгал зардал болон бусад шаардагдах зардлыг шийдвэрлэх.	ОНТ	Зардлыг шийдвэрлэсэн байх	5	Цагдаагийн албаны тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 1992 оны 43, 2000 оны 94 дүгээр тогтоолын дагуу цагдаагийн алба хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах, хэсгийн байрны үйл ажиллагааны урсгал зардлыг шийдвэрлэхэд анхаарч 14 сумын халаалтын зардалд 28.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгуулан шийдвэрлэсэн. Дэлгэрхангай сумын цагдаагийн хэсгийн байрны засварт 1.020.5 сая төгрөг, Хулд, Сайхан-Овоо, Өндөршил сумд согтуурал шалгах багаж авахад зориулж 7.921.600 төгрөг, Дэлгэрцогт сумын цагдаагийн автомашины засварт 4.0 сая төгрөг, хэсгийн алба хаагчдын эргүүл болон гэмт хэрэг шалгахад зориулан 8.898.650 төгрөгийг шатахууны зардалд, бусад зардалд 2.590.0 сая төгрөгийг тус тус шийдвэрлэж өгсөн.

					Хэрэгжилтийн хувь - 100
4.3	Дундаж хурдны хурд тодорхойлох хяналтын камерын системийг аймгийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрдөг улсын чанартай замд байршуулах, шаардлагатай төсөв хөрөнгийг шийдвэрлэх	-	Төсвийг шийдвэрлэсэн эсэх	1	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд санал хүргүүлж 2023 онд улсын төсвийн хөрөнгөөр Мандалговь хотыг бүрэн камержуулах зураг, төслийн ажилд шаардлагатай 30.0 сая төгрөгийг 2022 оны төсөвт тусгуулан тендерт шалгарсан “Сителком” компани зураг төслийн ажлыг хийж хүлээлгэн өгсөн. Мөн тус аймгийн төвийг дайран өнгөрч байгаа А0102 улсын чанартай, хатуу хучилттай авто замд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дундаж хурдны хурд тодорхойлох телекамер тавихаар шийдвэрлэсэн ба камерын зардал 80.0 сая төгрөгийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөр шийдүүлэхээр албан бичиг хүргүүлсэн. Хэрэгжилтийн хувь - 70
Тав. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээр					
5.1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байранд телекамер бүхий димапон систем нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	25,0 сая төг Орон нутгийн төсөв	Тоног төхөөрмжөөр хангасан эсэх	1	Дундговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын алба хаагч болон хоригдогч, хоригдлын аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор цагдан хорих байранд телекамер бүхий домофон системийг нэвтрүүлэхээр төлөвлөн 25.4 сая төгрөгийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шийдвэрлүүлэн 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдөр тендерийг нээхээр төлөвлөгдсөн байсан боловч 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Орон нутгийн төсвөөс батлагдсан хөрөнгөд тодотголд оруулж санхүүжилтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор буцаан татсан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын албан хэрэгцээнд 3,9 сая төгрөгний тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн.

					Хэрэгжилтийн хувь - 70
Зургаа. Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр					
6.1	Төрийн архивт нягтруулсан шүүгээ болон бусад техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, архивын баримт бичгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах	19.0 сая.төг Орон нутгийн төсөв	Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан тоо	4	Төрийн архивт баримт хамгаалалтын хайрцаг 100 ширхэг, 16 ширхэг зориулалтын нягтруулсан шүүгээ, хадгаламжийн 2 санд хяналтын камер, агааржуулалтын систем, хурдны скайнер, тусгай зориулалтын баримт хадгалахад зориулж 2 ширхэг шүүгээ зэргээр ханган, баримт бичгийн хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулахад нийт 19.0 сая төгрөгийг шийдвэрлэн зарцууллаа. Хэрэгжилтийн хувь - 100
Долоо. Шүүхийн шинжилгээний чиглэлээр					
7.1	Аймгийн Шүүхийн шинжилгээний албаны мэргэжлийн лабораторыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах.	6.9 сая.төг Улсын төсвийн хөрөнгө	Тоног төхөөрөмжөөр хангасан эсэх	1	Тус албанд 6.9 сая төгрөгний үнэ өртөг бүхий компьютер, 3 үйлдэлт хэвлэгч машин, зургийн аппарат тус бүр нэг, зөөврийн моторыг тус тус шийдвэрлэж техник, тоног төхөөрөмжийн хангалт хийгдсэн. Тус алба хими, биологийн лаборатори байгуулахаар шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэгч “Грийн Химистри” ХХК-тай хамтран үнийн судалгааг гаргаж, холбогдох газруудад албан бичгээр саналаа хүргүүлсэн. Хэрэгжилтийн хувь - 70
Найм. Хууль зүйн туслалцааны чиглэлээр					
8.1	Хууль зүйн туслалцааны төвийн салбарын өмгөөлөгчийг интернетийн орчин бүхий ажлын өрөө, тасалгаагаар ханган урсгал зардлыг хариуцаж, ажиллах нөхцөлийг бүрдүүлж шаардлагатай дэмжлэг үзүүлж хамтран ажиллах.	-	Байр, өрөөний тоо	1	Хууль зүйн туслалцааны төвийн тус аймаг дахь өмгөөлөгчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ажлын өрөө, тасалгаагаар бүрэн хангаж, интернет бүхий орчинг бүрдүүлэн, урсгал зардлыг аймгийн ЗДТГ-аас бүрэн хариуцан хэвийн ажиллуулж хэвшүүлсэн. Хууль зүйн туслалцааны төвөөс зохион байгуулсан цахим сургалтууд болон Хуульчийн багц цагийн сургалтанд бүрэн хамруулсан. Хэрэгжилтийн хувь -100
Хамтран ажиллах гэрээний гурав. Засаг даргын хүлээх үүрэг					

3.1.1	Холбогдох хууль тогтоомжийн дагуу энэхүү гэрээнд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг хүлээж, түүний үр дүнг Сайдын өмнө хариуцах.	-	Гэрээний хэрэгжилтийн хувь	89	Хууль зүй, дотоод хэргийн сайдаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг 90.8 хувьтай хэрэгжүүлэн ажиллаж, гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь тайлагналаа. Хэрэгжилтийн хувь - 100
3.1.2	Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээ болон түүний зарим хэсгийг гуравдагч этгээдээр (тухайн салбарт үл хамаарах төсвийн байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж гэх мэт) гүйцэтгүүлэхээр хариуцан гэрээлсэн бол тэдгээрийг тогтоосон хугацаанд гүйцэтгүүлэх.	-	Гүйцэтгэлийн хувь	-	2023 онд улсын төсвийн хөрөнгөөр Мандалговь хотыг бүрэн камержуулах зураг, төслийн ажилд шаардлагатай 30.0 сая төгрөгийг 2022 оны төсөвт тусгуулан тендерт шалгарсан “Сителком” компани зураг төслийн ажлыг хийж хүлээлгэн өгсөн. Хэрэгжилтийн хувь – 100 хувь
3.1.3	Улсын төсвийн хөрөнгөөр тодорхой арга хэмжээ, түүний санхүүжилт, харилцан хүлээх үүрэг хариуцлагын талаар тухайн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, хэлэлцүүлэн санал, дүгнэлтийг нь авах.		ИТХ-д оруулсан санал, дүгнэлтийн тоо	-	Тус хугацаанд улсын төсвийн хөрөнгөөр ямар нэгэн арга хэмжээ байхгүй болно. -
3.1.4	Үйл ажиллагааны зардлын хэмнэлтийг Сайдтай зөвшилцсөний үндсэн дээр хуульд заасны дагуу төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зориулан зарцуулах.		Зардлын зориулалтын дагуу зарцуулсан эсэх (тийм-1, үгүй-0)	1	2022 оны үйл ажиллагааны зардал хэмнэгдээгүй болно. -
3.1.5	Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Сайдын эрхлэх		Сумын Засаг дарга нартай	1	

	асуудлын хүрээний агентлаг, байгууллагуудын орон нутаг дахь газар, нэгжүүд, сумын Засаг дарга нартай тодорхой арга хэмжээ гүйцэтгүүлэх гэрээ болон тухайн салбарын байгууллагын ерөнхий менежертэй гэрээ байгуулан ажиллах.		гэрээ байгуулсан эсэх (тийм-1, үгүй-0)		Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх арга хэмжээ байхгүй байсан тул тусгайлсан гэрээ байгуулаагүй болно. -
3.1.6	Аймгийн Засаг даргатай байгуулах гэрээнд тухайн Засаг даргаас суманд ажиллаж байгаа нэгж, албадын алба хаагчийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг хангахтай холбоотой заалтуудыг тусгаж, үр дүнг тооцож ажиллах.		Холбогдох заалтыг гэрээнд тусгасан эсэх (тийм-1, үгүй-0)	1	Аймгийн Засаг даргаас сумдын Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээний Зорилт 3 буюу Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, үр дүнг дээшлүүлэх хүрээний 3.1-д суманд ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчийг орон байр, тээвэр, холбооны хэрэгсэл, согтуурал хэмжих багажаар хангах, бусад шаардлагатай урсгал зардлыг шийдвэрлэх заалтыг тусган 14 сумын халаалтын зардалд 28.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгуулан шийдвэрлүүлж ажилласан. Хэрэгжилтийн хувь - 100
3.1.7	Хэрэгжүүлсэн арга хэмжээний хагас, бүтэн жилийн тайланг, тогтоосон хугацаанд үнэн зөв гаргаж, Сайдад ирүүлэх.		Тайланг хугацаанд нь хүргүүлсэн тоо	2	Хууль зүй, дотоод хэргийн сайдаас аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний 5.1-д заасан хугацаанд буюу 6 дугаар сарын 10-ны өдөр хагас жил, 12 дугаар сарын 08-ны өдөр бүтэн жилийн тайланг тус тус тайлагнаж хугацаанд хүргүүллээ. Хэрэгжилтийн хувь - 100
3.1.9. Засаг дарга гэрээний хугацаанд Сайдын эрхлэх хүрээний асуудлаар дараах тусгайлан үүрэг хүлээнэ					
3.1.9.1	Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын орон нутаг дахь нэгж, албадын үйл ажиллагааг бэхжүүлэх, шаардлагатай	30,5 сая төг ОНТ	Үзүүлсэн дэмжлэг туслалцаа	45,0 сая төг	Цагдаагийн газарт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилгоор энгэрийн камер 7, хэт богино долгионы радио холбоо 6, мөн богино долгионы

	ажлын байр, техник тоног төхөөрөмжөөр хангах, тус салбарын албан хаагчдын орон сууцны барилга барих газар олгох, орон байраар хангах, бусад дэмжлэг үзүүлэх зэргээр тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх.				радио холбооны нөөц тэжээл 20 ширхэг зэрэг 12.700.000 төгрөгийн тоног төхөөрөмж, тусгай хэрэгсэл шийдвэрлүүлсэн. Мөн Цагдаагийн ерөнхий газрын Санхүү аж ахуйн албанд хүсэлт хүргүүлж 7,0 сая төгрөгийн өртөг бүхий дахин дамжуулах станц шийдвэрлүүлсэн. Сайнцагаан сумын 9 дүгээр багийн нутаг дэвсгэрт 1 га газрыг шийдвэрлэн төмс, хүнсний ногоо, жимсний мод тариалсан. Цагдаагийн газрын насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах өрөөний засвар, тохижилтын ажилд 5.0 сая төгрөгний дэмжлэг үзүүлж, Эрүүлжүүлэх баривчлах байрны агааржуулах төхөөрөмжийн 2.3 сая төгрөгийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шийдвэрлүүлсэн. Шүүхийн шинжилгээний албанд 6.9 сая төгрөгний үнэ өртөг бүхий компьютер, 3 үйлдэлт хэвлэгч машин, зургийн аппарат тус бүр нэг, зөөврийн моторыг тус тус шийдвэрлэж техник, тоног төхөөрөмжийн хангалт хийгдсэн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын албан хэрэгцээнд 3,9 сая төгрөгний тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн ба аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн “Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай” А/375 дугаар захирамжаар 3284м2, 1493м2 газрыг албан хаагчдын орон сууцны барилга барих газар олгосон. Аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд хууль, хяналтын байгууллагуудын алба хаагчдын орон байрны дэмжлэгт зориулан Цагдаагийн газрын цагдаа жолооч Д.Чимэддоржид 7.0 сая төгрөг, Улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч Ш.Чулуун, Ё.Батбаяр нарт тус бүр 10.0 сая төгрөгийг нийт
--	---	--	--	--	--

					27.0 сая төгрөгний дэмжлэг үзүүлээ. Мөн цэрэгжсэн байгууллагуудын хүсэлтийн дагуу Сүлд дурсгалын талбайн газрын асуудлыг шийдвэрлэсэн. Хэрэгжилтийн хувь - 100
3.1.9.2	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор хуулийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж ажиллах.	1.5 сая.төг Орон нутгийн төсөв	Зохион байгуулсан сургалтын тоо	24	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай шинэчлэн батлагдсан хууль болон түүнийг даган гарсан дүрэм, журам, стандартыг суртачлах зорилгоор тус онд 21 удаа танхимын сургалт, 3 удаагийн онлайн сургалтыг нийт давхардсан тоогоор 15 сум, 19 байгууллагын 623 албан хаагчийг оролцуулж, тэднийг арга зүй удирдлагаар ханган ажиллалаа. Хэрэгжилтийн хувь - 100
3.1.9.3	Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулж, батлан, Хууль зүй, дотоод хэргийн яаманд ирүүлж нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлснээр дагаж мөрдөх.	-	Батлагдсан захиргааны хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг Улсын нэгдсэн санд бүртгүүлсэн байх	2	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас “Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай”, “Газрын төлбөрийн бүсийн хил зааг, итгэлцүүр төлбөрийн хэмжээг тогтоох тухай”, Гурвансайхан, Сайхан-Овоо, Өндөршил сумдын “Малын тоо толгойд 2022 онд ногдуулах албан татварын хэмжээ тогтоох тухай”, Дэлгэрцогт сумын “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох тухай журам”-уудыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн. Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 дугаар зүйлийг баримтлан аймгийн “Орон нутгийн санг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах түүнд хяналт тавих журам”-ыг боловсруулахаар Dundgovi.gov.mn цахим хаягаар иргэдээс санал, хүсэлтийг хүлээн авч төсөлд тусган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит аравдугаар хуралдаанаар “Орон нутгийн санг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах түүнд хяналт тавих журам”-ын төслийг хэлэлцүүлэн баталж улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлсэн боловч

					тодорхой нөхцөл байдлаас шалтгаалан санд бүртгэгдээгүй хүлээгдэж байна. Хэрэгжилтийн хувь - 100
3.1.9.4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хорих ангид ял эдэлж буй хоригдлыг ажлын байраар хангах, хөдөлмөрлүүлэхэд дэмжлэг үзүүлж, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	-	Дэмжлэг үзүүлсэн эсэх	-	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт цагдан хорих байрны аж ахуй үйлчилгээнд нийт 4 хоригдол хорих ял эдэлж байгаа ба хоригдлуудын дунд бусдад төлөх гэм хорын хохиролтой хоригдол байхгүй. Хэрэгжилтийн хувь - 100
3.1.9.5	Нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтан, ялангуяа өсвөр насны ялтныг түүний нас, биеийн онцлогт тохирсон, нийтийн ашиг сонирхолд нийцсэн ажлын байраар хангах, гэмт хэргийн хор уршгийг ойлгуулахад чиглэсэн сургалт, хүмүүжлийн арга хэмжээнд хамруулах.	-	Сургалт, хүмүүжлийн арга хэмжээ зохион байгуулсан тоо	4	2022 онд нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн нийт 11 ялтанд хяналт тавин ажиллаж, 5 ялтны ялыг хорих ялаар сольж, 1 ялтныг ялаас чөлөөлж, 3 ялтан ял бүрэн эдлэж дууссан. Нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн 2 ялтны ялын биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. Нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн өсвөр насны ялтан байхгүй. Нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтанд гэмт хэргийн хор уршгийг ойлгуулах чиглэлээр 5 хоног бүр биечилсэн хяналт хийн 15 удаагийн яриа таниулга хийсэн. Хэрэгжилтийн хувь - 100
3.1.9.6	Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч иргэдэд үйлчилгээ үзүүлэх, ажиллах нөхцөлийг сайжруулж, уулзалтын өрөө, ажлын байраар бүрэн хангах.	Орон нутгийн төсөв	Байр, өрөөний тоо	1	Хууль зүйн туслалцааны төвийн тус аймаг дахь өмгөөлөгчийн үйл ажиллагааг дэмжин, иргэдэд үйлчилгээ үзүүлэх өрөө, тасалгаагаар бүрэн хангаж, интернет бүхий орчин бүрдүүлэн, урсгал зардлыг аймгийн ЗДТГ-аас бүрэн хариуцаж, хэвийн ажиллуулсан. Хууль зүйн туслалцааны төвийн аймаг дахь салбар зөвлөл нь төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгчдэгч нарт өмгөөллийн үйлчилгээг Дундговь аймгийн Цагдаагийн газрын Хэрэг бүртгэлт, Мөрдөн

					байцаалт, Прокурор, Шүүхийн шатанд 49 хэргийн 54 хүн(холбогдогч)-ий хууль ёсны эрх ашгийг хамгаалан өмгөөлөгчөөр оролцсон. Анхан шатны шүүхэд 39 хэргийн 40 хүн(холбогдогч)-ий хэрэг маргааныг шийдвэрлэж, хууль зүйн анхан шатны зөвлөгөөг 300 хүнд үзүүлж, өргөдөл, гомдол нэхэмжлэлийн эх гаргаж зөвлөгөө өгч ажилласан. Хэрэгжилтийн хувь - 100
3.1.9.7	Хуульт ёс, дэг журам, аюулгүй байдлыг хангах, иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалахад цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, олон нийтийн цагдаагийн үйл ажиллагааг бэхжүүлэх, нутаг дэвсгэрийн хэмжээнд гудамж, зам талбай, олон нийтийн газруудад камерын хяналтын систем нэвтрүүлэх.	Орон нутгийн төсөв	Олон нийтийн цагдаа ажиллуулсан эсэх (Тийм-1 Үгүй-0)	1	Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 22.423.066 төгрөгийг олон нийтийн цагдаагийн урамшуулалд зарцуулсан. Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/122 дугаартай тушаалаар батлагдсан “Олон нийтийн цагдаагийн дүрэм”-ийн 3.4 дэхь хэсэгт заасны дагуу нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлын хангах чиглэлээр 2022 онд ажиллуулах олон нийтийн цагдаагийн орон тоо, шаардагдах төсвийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлж шийдвэрлүүлсэн. Олон нийтийн цагдаагийн сонгон шалгаруулалтын зарыг тогтмол явуулж, шинээр 2 олон нийтийн цагдаа томилуулсан. Мөн олон нийтийн цагдаагаар ажиллаж байсан 1 ажилтан цагдаагийн алба хаагчийн сонгон шалгаруулалтад тэнцэн ХСИС-ийн цагдаагийн сургуульд суралцаж байна. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд санал хүргүүлж, 2023 онд улсын төсвийн хөрөнгөөр Мандалговь хотыг бүрэн камержуулах зураг, төслийн ажилд шаардлагатай 30.0 сая төгрөгийг 2022 оны төсөвт тусгуулан тендерт шалгарсан “Сителком” компани зураг төслийн ажлыг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.

					Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр Баянжаргалан суманд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэхээр 20.0 сая төгрөгийг шийдвэрлэн тендер зарлаж, сумын төвийг хяналтад авах 4 цэгт, 4 ширхэг PTZ теле камер байршуулан ашиглаж байна. Аймгийн төвийн хуучин камеруудыг засварлаж, төв зам дагуу 10 цэгт 21 ширхэг камерыг суурилуулж, хэвийн ажиллагааг ханган ажиллалаа. Хэрэгжилтийн хувь - 100
3.1.9.8	Салбарын нэгж, алба хаагчийн ажлын байрыг мэдээллийн сүлжээнд холбох арга хэмжээ авч, ажил үүргээ цахим хэлбэрээр явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх.	-	Мэдээллийн сүлжээнд холбогдсон эсэх (тийм-1, үгүй-0)	1	Цагдаагийн газрын 14 сумын цагдаагийн хэсгийн байрыг цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээ "Direct access"-д бүрэн холбосон ба 2022 онд Цагдаагийн байгууллага нь албан бичиг хөтлөлтийн цахим системийг нэвтрүүлсэн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын нийт 35 алба хаагчдын ажлын байрыг "ERP цахим систем", "ШШГБ хүний нөөцийн систем", "ХНУМТ" цахим системүүдэд бүртгэлжүүлэн үйл ажиллагаандаа ашиглаж, мэдээ мэдээллийг цахимаар түргэн шуурхай солилцон ажиллаж байна. Хэрэгжилтийн хувь - 100
3.1.9.10	Улсын бүртгэлийн цахимжуулалтын ажлыг эрчимжүүлэх, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын баримтын хадгалалт, хамгаалалт, нөхцөлийг сайжруулах.	-	Бүртгэлүүдийг цахим санд шинэчлэн оруулсан эсэх (тийм-1, үгүй-0)	1	Иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулах ажлын хүрээнд иргэний гэр бүлийн 1212 бүртгэлийн 3771 хуудас, иргэний үнэмлэхийн 1766 бүртгэлийн 3000 хуудас, шилжилт хөдөлгөөний 1671 бүртгэлийн 3346 хуудас, гадаад паспортын 100 бүртгэлийн 100 хуудас нийт 4749 бүртгэлийн 10217 хуудас баримтыг цахимжуулсан бол Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 440 иргэн хуулийн этгээдэд бүртгэлийн үйлчилгээг үзүүлж 3800 хуудас хувийн хэргийг цахимжуулан

					мэдээллийн санд оруулсан. Харин Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 2811 бүртгэл бүртгэж, анхны бүртгэлийн хувийн хэргийн нийт 5490 хуудас, өмчлөх эрх шилжих 483 бүртгэлийн 2898 хуудас, барьцааны гэрээний 1254 бүртгэлийг 9170 хуудас, бусад бүртгэлээр 671 хуудас нийт 18230 хуудас цахимжуулж, улсын бүртгэлийн нийт 8000 бүртгэлийн 32247 хуудас архивын баримтын шаардлага хангасан эх нотлох баримтыг цахимжуулсаны үр дүнд баримтыг ашиглах, засварлах программын хэрэглээ сайжирч цаг хугацааг хэмнэж мэдээллийг түргэн шуурхай солилцох, дамжуулах нөхцөл боломж бүрэн бүрдсэн. Хэрэгжилтийн хувь - 100
3.1.9.11	Засаг даргын Тамгын газрын Хуулийн хэлтэс нь Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэнд чиглэсэн эрх зүйн сургалт, сурталчилгаа явуулж, хууль тогтоомжийн эмхэтгэл, гарын авлага гарган ажиллаж, тайланг улирал бүр Хууль зүй, дотоод хэргийн яамны Эрх зүйн хэлтэст ирүүлж, хамтран ажиллах.	-	Тайлангийн тоо	2	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”, аймгийн Засаг даргын шийдвэрээр 2022 оныг “Хүний хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан иргэд, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага, татвар төлөгчдийн эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх ажлыг танхимаар зохион байгуулан, эрх зүйн сургалтыг 14 удаа 840 хүнд, сурталчилгаа, хэлэлцүүлгийг 3 удаа 541 хүнд тус тус зохион байгууллаа. “Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар”, “Дундговь Эрх зүйн хөтөч”, “Сумдын эрх зүйн хөтөч” “Дундговь Насан туршийн боловсрол”, “Авлигагүй Дундговь” пэйж хуудсуудаар иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх сурталчилгаат үйл ажиллагаануудыг зохион байгуулан тус хэлтсийн Эрх зүйн ажлын тайлан, мэдээг 06, 12 дугаар

					сарын 10-ны дотор тус тус хугацаанд нь хүргүүлж тайлагнасан. Хэрэгжилтийн хувь - 100
3.2.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 зүйлд заасны дагуу тухайн жилд зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 40-өөс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ.	59.1 сая төг Орон нутгийн төсөв	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд 40-өөс доошгүй хувийг зарцуулах	147.5 сая төг	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 зүйлд заасны дагуу 2021 онд төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгээс 147.585.600 төгрөгийг 2022 оны аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд тусгуулан тус онд дээрх үйл ажиллагааг зохион байгуулахад 100 хувь зарцуулсан. Хэрэгжилтийн хувь - 100
3.3.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3 дахь хэсэгт “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах саналаа иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах” гэж заасны дагуу харьяалах нутаг дэвсгэртээ байгуулсан түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн тогтвортой үйл ажиллагааг хангаж ажиллана.	-	Түр хамгаалах байртай болсон байх /тийм-1 Үгүй-0/	1	Тус аймаг дахь Цагдаагийн газрын ашиглаж байсан хуучин барилгыг засварлаж гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийг байрлуулах “Түр хамгаалах байр”-ыг байгуулах зураг төсвийг гарган хөрөнгийг шийдвэрлэх талаар холбогдох газруудад хүсэлт хүргүүлсэн боловч Төрийн хэмнэлтийн хуультай холбогдуулан хөрөнгө нь шийдвэрлэгдээгүй. Монгол улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Л.Нямгэрэлийг тус орон нутагт ажиллах үеэр гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг танилцуулж, “Түр хамгаалах байр”-ны асуудлыг шийдвэрлэх нэн шаардлагатай байгаа талаар танилцуулсан. Хэрэгжилтийн хувь - 0
3.4.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт	Орон нутгийн төсөв	Олон нийтийн цагдаагийн тоо	6	Төр, хувийн хэвшлийн байгууллага аж ахуй нэгжүүдийг олон нийтийн эргүүлд ажиллуулах, хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд эргүүлийн

	“Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн бус байгууллага болон, хорооны Засаг даргын саналыг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ эргүүлийн үүрэг гүйцэтгэх олон нийтийн байцаагчийг томилон ажиллуулна.				үүрэг гүйцэтгэх олон нийтийн байцаагчийг томилон нэгдсэн хуваарь гарган баталж хамтран ажиллах талаар Сайнцагаан сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд албан бичиг хүргүүлэн хамтран ажиллалаа. Тус аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас 2022 онд ажиллах олон нийтийн цагдаагийн тоог 6 байхаар тогтоосон ба одоогоор тус аймгийн хэмжээнд 2 олон нийтийн цагдаа ажиллаж байна. Олон нийтийн цагдаагийн сонгон шалгаруулалтын зарыг тогтмол явуулж байгаа боловч цалин урамшуулал бага байгаагаас шалтгаалан ажиллах сонирхолтой иргэд төдийлөн ирэхгүй байна. Хэрэгжилтийн хувь - 70
	100 хувь -29, 70 хувь-4, 0 хувь-2	Хэрэгжилтийн хувь – 90.8			

ХЯНАСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА /Ц.МӨНХБАТ/

ХЭРЭГЖИЛТИЙГ ТООЦОН ГАРГАСАН:
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА /Л.БАЯРСАЙХАН/

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН /Э.ОДОНЧИМЭГ/